# НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
# ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 31 өдөр    Дугаар А/165    Улаанбаатар хот

Томуу, томуу төст өвчнөөс
урьдчилан сэргийлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/373 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1247 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1."Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, идэвхжил, дэгдэлтийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөний дагуу сургуулийн өмнөх боловсролын байгууллагын суралцагч нарт томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх, дархлаа дэмжих, гар угаах, хоолой зайлах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулахыг Дүүргийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн болон харьяа Эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай

3.Томуу, томуу төст өвчний үед эрүүл мэндийн байгууллагад шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, лабораторийн хэрэгсэл, оношлуур, урвалж бодисын нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлж, хүлээн авах яаралтай тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллахыг харьяа Эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4.Томуугийн харуулдан тандалтын нэгжүүд томуу, томуу төст өвчний тархалтын үе шатанд тохируулан 7 хоног бүр тохиолдлын тодорхойлолтын дагуу 2-10 сорьц харьяа дүүргийн вирус судлалын лабораторт хүргүүлэхийг Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

5.Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Б.Батцоож)-т, Нийтийн эрүүл ахуй, халдварт өвчний хэлтэс (З.Болормаа)-т даалгасугай.

6.Төлөвлөгөөнд заасан хугацаанд тайлан мэдээ ирүүлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг харьяа Эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

7.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, удирдлагын хэлтэс (У.Бат-Очир)-т даалгасугай.

ДАРГА    П.ЭРХЭМБУЛГАН

9023070010

1550001453

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн
А/465 тушаалын хавсралт

9023070010
9077156 СБТ22555

## Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, идэвхжил, дэгдэлтийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | 2024 оны IY улирал | | | 2025 оны I улирал | | | 2025 оны II улирал | | | 2025 оны III улирал | | | Хариуцах байгууллага, нэгж | Хамтран ажиллах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | X | XI | XII | I | II | III | IY | Y | YI | YII | YIII | IX | | |
| Нэг.Томуу, томуу төст өвчин нэмэгдэх, дэгдэлт гарах магадлалтай цаг үеийг угтуулж, урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах | | | | | | | | | | | | | | | |
| 1. | ТТТӨ-ний өнгөрсөн улирлын өвчлөлийн болон тандалт тусламж үйлчилгээ, хариу арга хэмжээний байдалд дүн шинжилгээ хийх; | | | | | | | | | | | | | НЭМГ, ХЭМБ | ХӨСҮТ |
| 2. | Нийслэлийн хэмжээнд “ТТТӨ-с урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, идэвхжил, дэгдэлтийн үед хэрэгжүүлэх, үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулах; | | | | | | | | | | | | | НЭМГ, ХЭМБ | ЭМЯ, НЗДТГ, ХӨСҮТ |
| 3. | ТТТӨ-нөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах, идэвхжил, дэгдэлтийн үед ажиллах талаар гарсан холбогдох тушаал, шийдвэр, төлөвлөгөөг танилцуулах, судлуулах; | | | | | | | | | | | | | ӨЭМТ, ДЭМТ, НЭ, НТТТ | НЭМГ, ДЗДТГ |
| 4. | 0-5 насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, эрхтэн тогтолцооны эмгэг, архаг хууч өвчтэй эрсдэлт бүлгийн хүн амын судалгаа гаргах; | | | | | | | | | | | | | ӨЭМТ ДЭМТ | НЭМГ НБГ |
| 5. | Хүүхдийн байгууллага руу чиглэсэн ТТТӨ-өөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх; | | | | | | | | | | | | | НЭМГ, ХЭМБ | НБГ, НГБХЗГ, ДЗДТГ |
| 6. | Улирлын томуугийн вакцинд хамрагдах эрсдэлт бүлгийн хүн амын судалгааг гаргах, дархлаажуулалтыг зохион байгуулах; | | | | | | | | | | | | | НЭМГ, ХЭМБ | ЭМЯ, ХӨСҮТ, НБГ |
| 7. | Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулах; | | | | | | | | | | | | | НЭМГ, ХЭМБ | ЭМЯ, ХӨСҮТ, АШУҮИС |
| 8. | Нийслэлийн хэмжээний цэцэрлэгийн багш, ажилтнуудад томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх талаар сургалт зохион байгуулах; | | | | | | | | | | | | | ДЭМТ НЭ ӨЭМТ | НБГ, ДЗДТГ |
| 9. | Цэцэрлэгийн хүүхдүүдэд томуу томуу төст өвчнөөс сэргийлэх, дархлаа дэмжих, гар угаах, хоолой зайлах, | | | | | | | | | | | | | ДЭМТ НЭ ӨЭМТ | НБГ, НЭМҮТ, ХӨСҮТ |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эрүүл зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах; | | | | | | | | | | | | | | |
| 10. | ТТТӨ-өөс урьдчилан сэргийлэх иргэдэд зориулсан зөвлөмжийг олон нийтийн цахим сүлжээгээр түгээх; | | | | | | | | | | | | | НЗДТГ, НЭМГ, | ЭМЯ, НЭМҮТ |
| 11. | Томуугийн харуулдан тандалтын нэгжүүд ТТТӨ-ий тархалтын үе шатанд тохируулан 7 хоног бүр тохиолдлын тодорхойлолтын дагуу өрхийн эрүүл мэндийн төв 2-10 сорьц харьяа дүүргийн вирус судлалын лабораторт хүргүүлэх; | | | | | | | | | | | | | ӨЭМТ | |
| 12. | ТТТӨ-ний үед эрүүл мэндийн байгууллагад шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, лабораторийн хэрэгсэл, оношлуур, урвалж бодисын нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлэх; | | | | | | | | | | | | | НЭМГ, ХЭМБ | ЭМЯ, ХӨСҮТ |
| 13. | Орны нэгдсэн төлөвлөгөө гаргах, бэлтгэл ажлыг хангах; | | | | | | | | | | | | | НЭМГ | ЭМЯ |
| 14. | ТТТӨ-ний идэвхжил, дэгдэлтийн үед ажиллах хүний нөөцийн судалгааг гаргаж, бэлтгэл ажлыг хангах; | | | | | | | | | | | | | НЭМГ, ХЭМБ | ЭМЯ, ЭМХТ |
| 15. | ТТТӨ-ний үед НТТТ-ийн дуудлага хүлээн авах шугамыг нэмэгдүүлэх, эмнэлгийн хүлээн авах, яаралтай тусламжийн тасгийн хүний нөөц, автомашин, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, төлөвлөлт гаргах; | | | | | | | | | | | | | НЭМГ, ХЭМБ | ЭМЯ, ХӨСҮТ, НЭМҮТ |
| 16. | ТТТӨ-нөөс урьдчилан сэргийлэх, бэлтгэх ажлыг хангах талаар холбогдох байгууллагад эргэн мэдээлэх, сануулах, хамтран ажиллах, санал, хүсэлт, албан бичгийг цаг тухайд нь илгээх; | | | | | | | | | | | | | НЭМГ | - |
| 17. | Төлөвлөгөөт хугацаанд явцын /2 долоо хоногт 1 удаа/ болон нэгдсэн тайлан ирүүлэх; | | | | | | | | | | | | | ХЭМБ | - |
| Хоёр. Томуу ,томуу төст өвчний идэвхжлийн үеийн үйл ажиллагааг оновчтой, үр дүнтэй зохион байгуулах | | | | | | | | | | | | | | | |
| 18. | ТТТӨ болон түүний хүндрэлээс урьдчилан сэргийлэх, ТТТӨ-ийг гэрээр эмчлэх, асаргаа сувилгаа хийх, өвчтэй хүүхдийн хоол, тэжээл, эмийн зохистой хэрэглээ зэрэг сэдвүүдээр хүн амын дунд мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг зурагт болон олон нийтийн сүлжээний хэрэгслээр тогтмол явуулах; | | | | | | | | | | | | | НЭМГ | ЭМЯ, НЭМҮТ |
| 19. | Нийслэл, дүүргийн Шуурхай удирдлагын нэгж нь тандалт, мэдээ, мэдээллийг шуурхай солилцож, идэвхжлийн үеийн хариу арга хэмжээг зөв төлөвлөн, үйл ажиллагааг оновчтой, үр дүнтэй зохион байгуулах; | | | | | | | | | | | | | НЭМГ, ХЭМБ | ЭМЯ, ДЗДТГ |
| 20. | Амьсгалын замын өвчлөл, Томуу томуу төст өвчний үеийн 0-5 насны хүүхдийн гэрийн эргэлтийг эрчимжүүлэх, зохион байгуулалт, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллах; | | | | | | | | | | | | | НЭМГ, ХЭМБ | - |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 21. | ТТТӨ-ний амбулатори, түргэн тусламжийн болон орны ачааллын тандалтын мэдээг цаг тухайд нь өгөх; | | | | | | | | | | | | | НЭМГ, ХЭМБ | МХХЭМБНХ |
| 22. | Идэвхжлийн үед ДЭМТ, ӨЭМТ-д зөвлөгөө өгөх нээлттэй утас ажиллуулах; | | | | | | | | | | | | | НЭМГ | ДЭМТ, ӨЭМТ |
| 23. | Идэвхжлийн үед амбулаторийн эмч нарыг уртасгасан цагаар ажиллуулах; | | | | | | | | | | | | | НЭМГ | ДЭМТ, ӨЭМТ |
| 24. | Эрүүл мэндийн яам болон бусад яамны харьяа эмнэлэгт насанд хүрэгчдийн тусламж үйлчилгээг түр шилжүүлэх, хүүхдийн ор дэлгэх саналыг Эрүүл мэндийн яаманд хүргүүлэх; | | | | | | | | | | | | | НЭМГ | ЭМЯ |
| 25. | Хүүхдийн байгууллагад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө, сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах; | | | | | | | | | | | | | НЭМГ | НБГ, ДЗДТГ |
| 26. | Тусгаарлах өрөөний бэлэн байдлыг хангаж, хүлээн авахаар ирж байгаа өвчтөнг эрэмбэлэн ангилж, зөв үнэлэн, зайлшгүй шаардлагатай өвчтөнг хүлээн авах; | | | | | | | | | | | | | ХЭМБ | НЭМГ |
| 27. | Эмнэлгийн хүлээн авах тасгаас зөвлөгөө аван буцсан, эмнэлэгт хэвтээд гарсан хүүхдийн эмчилгээг стандартын дагуу зааж, зөвлөх, ДЭМТ, ӨЭМТ-д эргэн мэдээлэх; | | | | | | | | | | | | | НЭМГ, ХЭМБ | НЭМГ, ХЭМБ |
| **Гурав. Томуу, томуу төст өвчний дэгдэлт гарсан үед шаардагдах арга хэмжээг шуурхай зохион байгуулах** | | | | | | | | | | | | | | | |
| 28. | Нийслэл, дүүргийн Шуурхай удирдлагын нэгж нь салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, тохиолдлын удирдлагын тогтолцоонд шилжин ажиллах; | | | | | | | | | | | | | НЭМГ, ХЭМБ | НЗДТГ, ДЗДТГ |
| 29. | Эрүүл мэндийн ажилтан, резидент эмч нарыг шаардлагатай эрүүл мэндийн байгууллагад төлөвлөгөөний дагуу томилон ажиллуулах саналыг Эрүүл мэндийн яаманд хүргүүлэх; | | | | | | | | | | | | | НЭМГ | ЭМЯ, ЭМХТ, АШУҮИС |
| 30. | Нэмэлтээр түр эмнэлэг дэлгэх асуудлыг төр захиргааны болон мэргэжлийн байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх; | | | | | | | | | | | | | НЭМГ, ХЭМБ | ЭМЯ, НЗДТГ, ХӨСҮТ, ДЗДТГ, МХХЭМБНХ |
| 31. | Орны зохицуулалтыг хийж, яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасгийн тоног төхөөрөмж, хүний нөөцийг нэмэгдүүлэх; | | | | | | | | | | | | | НЭМГ, ХЭМБ | ЭМЯ, НЗДТГ, ХХЭМБ |
| 32. | Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг дайчлан ажиллуулах нэгдсэн төлөвлөлтийг хийх, зохион байгуулалт, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллах; | | | | | | | | | | | | | НЭМГ | - |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 33. | Эрсдэлт бүлгийн хүн амын өрхийн эмчийн үзлэгийг гэрийн эргэлтэд шилжүүлж, биеийн байдал хөнгөн болон дунд үед гэрээр эмчлэх, зөвлөгөө, зөвлөмж өгөх; | | | | | | | | | | | | | НЭМГ, ХЭМБ | ДЭМТ ӨЭМТ |
| 34. | Иргэдэд ТТТӨ-өөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулж. инфографик, зөвлөмж, танилцуулгыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол түгээх; | | | | | | | | | | | | | НЭМГ, ХЭМБ | НЗДТГ |
| 35. | Сайн дурын идэвхтэнийг эрүүл мэндийн боловсрол олгох, нийгмийн халамжийн ажилд дайчлан ажиллуулах; | | | | | | | | | | | | | НЭМГ, ХЭМБ | ДЗДТГ |

## ТОВЧИЛСОН ҮГ БА ТАЙЛАЛ

| | |
|---|---|
| НЗДТГ | Нийслэлийн засаг даргын Тамгын газар |
| ДЗДТГ | Дүүргийн засаг даргын Тамгын газар |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| ЭМХТ | Эрүүл мэндийн хөгжлийн төв |
| НЭМГ | Нийслэлийн эрүүл мэндийн газар |
| НБГ | Нийслэлийн боловсролын газар |
| АШУҮИС | Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургууль |
| МХХЭМБНХ | Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгулллагуудын нэгдсэн холбоо |
| ХЭМБ | Харьяа эрүүл мэндийн байгууллага |
| ХХЭМБ | Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага |
| НЭ | Нэгдсэн эмнэлэг |
| ДЭМТ | Дүүргийн эрүүл мэндийн төв |
| ӨЭМТ | Өрхийн эрүүл мэндийн төв |
| ТБТББ | Төрийн болон төрийн бус байгууллага |